



216

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ ОНӨААТУГ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 1/52

Улаанбаатар хот

«Серверийн өрөө, түүнийг ашиглах журам
батлах тухай»

Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтоолоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус нэгтгэлийн «Серверийн өрөө, түүнийг ашиглах» журмыг хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын үйл ажиллагаанд ажиллахыг мөрдлөг болгон ажиллахыг байгууллагуудын удирдлагуудад, мэдээлэл, мэдээллийн систем, түүний дэд бүтцийн аюулгүй байдалтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагаанд ажиллахыг нийт албан хаагчдад Үүрэг болгосугай.
3. Энэхүү журмыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн мөрдүүлж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулж ажиллахыг Ерөнхий инженер, Техник технологи бодлого төлөвлөлтийн хэлтэс /Б.Энхцаг-/ даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Г.ТӨМӨРБААТАР



11190003

“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ЫН
Захирлын 2019 оны... дугаар сарын ...-НИЙ
өдрийн А/... дугаар тушаалын хавсралт

TTT2527 № 5893704

СЕРВЕРИЙН ӨРӨӨ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1.“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ЫН сервер компьютеруудыг байрлуулах, өрөө, тасалгаа, түүнд тавигдах шаардлага, түүнийг зүй зохистой ашиглах, серверийн хэвийн үйл ажиллагааг энэхүү журмаар хангана.
- 1.2. Шүүхийн сервер компьютер, сүлжээний үндсэн төхөөрөмж нэг бүрийг эрх бүхий мэдээллийн технологийн мэргэжилтэн /цаашид “мэргэжилтэн” гэх/ хариуцаж мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй.

Хоёр. Серверийн өрөө

- 2.1. Серверийн өрөөг нарны гэрэл шууд тусахгүй, ус чийггүй, халуун хүйтний хэлбэлзэл бага, хүчтэй соронзон орноос хол, тоосорхог бус орчинд сонгоно.
- 2.2. Серверийн өрөө нь хөргөлтын төхөөрөмж, кабель тараагч сувагчлал, цахилгаан тэжээлийн самбартай байна. Эдгээр зүйл нь бүгд техникийн нөхцөл стандарт дүрмийн дагуу шийдвэрлэгдсэн байна.
- 2.3. Серверийн өрөөнд зогсууруудыг нэгэн шугаманд эгнээ эгнээгээр жигд байрлуулна. Зогсуур бүр дугаартай байна.
- 2.4. Серверийн өрөөний зогсуурт сервер компьютер, рутор, свич, кабел, тэжээлийн залгуур болон бусад шаардлагатай төхөөрөмжийг тавиур дээр байрлуулах шаардлагатай. Тавиур тус бүрийг дугаарласан байна. Мөн тавиур дээрх тоног төхөөрөмжийн эд анги тус бүрийг дугаарласан байна.
- 2.5. Серверийн өрөө нь галын аюулгүй байдлыг бүрэн хангасан байна. Мөн хөдөлмөрийн болон техникийн нөхцөл дүрмийн дагуу бүрэн гэрэлтүүлэгтэй байна.
- 2.6. Серверийн өрөө нь стандартын дагуу галын болон аваарын дохиолол, хяналтын камер, чийгшүүлэгч төхөөрөмжэй байна.
- 2.7. Серверийн өрөөнд агааржуулалт, халаалтыг мэдрэх тоног төхөөрөмжийг суурилуулна. Эдгээр тоног төхөөрөмж нь 24 цагийн турш тогтмол ажиллагаатай байна.
- 2.8. Серверийн өрөөн дэх системүүдийн кабель шугамын (дотоод сүлжээ, E1, UTP кабелийн холболт г.м) холболтыг нягт нямбай хийнэ. Бүх кабель шошготой байна.
- 2.9. Кабелиудыг татаж байрлуулахдаа тухайн тоног төхөөрөмжтэй ажиллахад саад болохооргүй эмх цэгцтэй татна.
- 2.10. Цахилгаан зайд тэжээл хариуцсан инженерээр серверийн өрөөн дэх тоног төхөөрөмжүүдийн цахилгаан эрчим хүчний нийт зарцуулалтыг тооцоолуулсан байна.
- 2.11. Серверийн өрөөнд шаардлагатай цахилгаан эрчим хүчний хэмжээг (чадал) цахилгааны автомат хайрцаг дээр бичнэ.

Гурав. Серверийн өрөөнд нэвтрэх

3.1. Серверийн өрөө, тасалгаанд зөвхөн тамгын газрын дарга, мэргэжилтэн, тусгай зөвшөөрөл бүхий албан тушаалтан нэвтрэнэ.

3.2. Серверийн өрөөг эзэнгүй үед хаалгыг нь байнга түгжинэ. Түлхүүрийг мэргэжилтэн хадгална. Серверийн өрөөний хаалга хурууны хээ, кодоор онгойдог байж болно.

Дөрөв. Серверийн өрөөнд байх анхааруулах тэмдэгнүүд

4.1. Серверийн өрөөн дэх мэдээллийн самбар дээр дараах мэдээллийг байрлуулна. Үүнд:

- 4.1.1. Серверийн өрөөнд идэж, уухыг хориглосон тэмдэг;
- 4.1.2. Серверийн өрөөнд зөвшөөрөлгүй орохыг хориглосон тэмдэг;
- 4.1.3. Чухал шаардлагатай утасны дугаарууд;
- 4.1.4. Тамгын газрын даргын утасны дугаар;
- 4.1.5. Мэдээллийн технологийн мэргэжилтний утасны дугаар;
- 4.1.6. Онцгой тусламжийн үйлчилгээний утасны дугаар

Тав. Серверийн өрөөнд дараах зүйлүүдийг хориглоно

5.1. Тамхи татах;

5.2. Зориулалтын бус тоног төхөөрөмж болон эд хогшил байлгах;

5.3. Гадны хүн зөвшөөрөлгүй нэвтрэх;

5.4. Шатамхай буюу тэсрэх дэлбэрэх зүйл оруулах;

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөний улмаас сервер болон сүлжээний үндсэн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд ямар нэгэн гэмтэл saat ал гаргасан, хохирол учруулсан, серверийн өрөөний журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.